



## ЗӨВЛӨМЖ

### #1. ЗӨВЛӨМЖ

*Авлигатай тэмцэх газрын 2018 оны 4 дүгээр сарын 30-ны зөвлөмжид дурдсан зөрчил, дутагдал дахин гарч байгаад дүгнэлт хийх, таслан зогсоох.*

**Нэг.** Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3-т "энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж **нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана**", 3.1-т "Засаг даргын нөөц хөрөнгийг **Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн** тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна." гэж тус тус заасныг баримтлан хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, Дундговь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн үлдэгдэл 2018 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар 29 715 509 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нийт батлагдсан хөрөнгийн 30%-д хүрэхгүй байна. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар нөөц хөрөнгөөс гаргах зардлыг урьдчилан хэлэлцдэггүй, гүйцэтгэлээр нь хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж, хэлэлцэн захирамж гаргадаг. Түүнчлэн урамшуулал, тэмцээн уралдаан, мэндчилгээ дэвшүүлэх зэрэгт 2017 онд 196 418 744 төгрөг зарцуулсан нь батлагдсан хөрөнгийн 76.7%, 2018 онд 114 895 800 төгрөгийг зарцуулсан нь батлагдсан хөрөнгийн 67.2%-тай тэнцэж байна.

**Хоёр.** Дундговь аймгийн хэмжээнд 2016, 2017 онуудад 2 албан хаагч тухайн албан тушаалд томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргаагүй зөрчил гаргаж байсан нь 2018 онд мөн давтагджээ. Тухайлбал, Гурвансайхан сумын 5 дугаар багийн Засаг дарга Ж.Балдан, Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын даргын үүрэг гүйцэтгэгч Д.Эрдэнэбаатар, Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Ганбаатар нарын 3 албан тушаалтан томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргаагүй зөрчилд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу хариуцлага тооцуулаад байна.



**Гурав.** Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтгүй, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт өгөөгүй, сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалтад тэнцээгүй, нөөцөд бүртгэгдээгүй 13 иргэнийг 2016 онд, 9 иргэнийг 2017 онд төрийн захиргааны албан тушаалд томилон ажиллуулж байсан бол 2018 онд энэ төрлийн зөрчлийг давтан гаргаж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөөр байна. Тухайлбал, Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтын шалгалт өгөөд 2 ч удаа тэнцээгүй иргэн О.Түмэнбаатарыг Сайхан-Овоо сумын сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгчээр, мөн шалгалтад тэнцээгүй иргэн С.Сугирсүрэнг Луус сумын цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр, иргэн Э.Батцэцэгийг Адаацаг сумын цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр, иргэн Д.Энхмааг Сайнцагаан сумын 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр, шалгалт өгөөгүй иргэн Д.Болормааг Гурвансайхан сумын цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр тус тус томилсон.

**Дөрөв.** Шүүхийн шийдвэрийн дагуу 2016-2017 онд ажилдаа эгүүлэн томилогдсон 9 хүнд олгосон 36 126 397 төгрөгийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ зохион байгуулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хяналт, аудитын албанаас 4 хүнд олгосон 17 545 337 төгрөгийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаас гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан бол бусад 5 хүнд олгосон 18 581 060 төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй.

## #1. ЗӨВЛӨМЖ

*Авлигатай тэмцэх газрын 2018 оны 4 дүгээр сарын 30-ны зөвлөмжид дурдсан зөрчил, дутагдал дахин гарч байгаад дүгнэлт хийх, таслан зогсоох.*



## #2. ЗӨВЛӨМЖ

**Хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, түүнд тавих хяналтыг чангатгах.**

Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ”-ний 23.1.3-т аймаг, нийслэлийн Засаг даргаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгоход 250 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж авахаар тогтоосон. Гэтэл аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тусгай зөвшөөрөл олгох, сунгахдаа тэмдэгтийн хураамжийг төсөвт төвлөрүүлж байгаагүй. Харин тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнэ гэж ямар субъект тогтоосон нь тодорхойгүй 8 800 төгрөгийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн М.Энхтуяа өөрийн ХААН банкин дахь 5450229214 тоот дансаар хүлээн авч, улмаар 38 сургуулиас хүлээн авсан 334 400 төгрөгийг газрын дарга Ц.Бумангэрэлийн ХААН банкин дахь 5450228630 тоот дансанд шилжүүлсэн байв. Ц.Бумангэрэлтэй уулзаж, гэрчилгээний үнэ өөрийн дансанд шилжүүлсэн мөнгийг хүлээж авч, үнэт цаасны компанид шилжүүлсэн баримтыг үзүүлэхийг мэдэгдсэн боловч энэ тухай танилцуулаагүй.

Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2017-2018 онуудад 14 аж ахуйн нэгж, байгууллагад шинээр олгож, 107 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж ажилласан. Орон нутгийн төсөвт 2018 онд шинээр 4 байгууллагаас 2 100 000 төгрөг, хугацаа сунгасан 3 байгууллагаас 420 000 төгрөг, нийт 2 520 000 төгрөг төвлөрүүлж бусад (үүний 1 нь ОНӨААТҮГ ба тус баазад 2 төрлийн) байгууллагаас тэмдэгтийн хураамжийг аваагүй ба зарим байгууллагаас дутуу төвлөрүүлсэн байлаа. Түүнчлэн нэр бүхий 6 жуулчны баазад согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 3 сар (2018.07.25-2018.10.1)-ын хугацаатай олгосон нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7-д заасан “Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар, согтууруулах ундаа импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тус тус сунгана.” гэснийг зөрчсөн.



Мөн эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр 2017 онд 5 (*Сайн түшиг, СОСУ, Мон хаар бор, Хантүшиг дөнт, Угтаал мандал мед*), 2018 онд 1 (*Говийн оточ сувилал*)-ийг тус тус олгож, мөн онуудад нийт 56 (*сумдын ЭМТ-15, сумын ЭЭС-15, Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, хувийн эмнэлэг-ортой 2, үүдэн эмнэлэг 8, эм ханган нийлүүлэх байгууллага – 2, эмийн сан – 10, сувилал – 1, ариутгал -1*) байгууллагын зөвшөөрлийг сунгасан байх ба улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн төвлөрүүлдэг талаар тодруулахад хариуцсан албан тушаалтан тодорхой мэдээлэлгүй байв. Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ”-ний 23.1.1-т аймаг, нийслэлийн Засаг даргаас улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах зөвшөөрлийг олгоход 400 000 төгрөг байхаар тогтоосон байна.

## #2. ЗӨВЛӨМЖ

**Хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, түүнд тавих хяналтыг чангатгах.**

## #3. ЗӨВЛӨМЖ

**Хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай” 142, 2018 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам батлах тухай” 73 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгох, Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдүүлэх**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 142 дугаар тогтоолоор “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай” баталсан нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан “Энэ хуулийн 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.” гэснийг, мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 73 дугаар тогтоолоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ыг баталсан нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. ...” гэснийг зөрчсөн. Өөрөөр хэлбэл, хуулиар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэр гаргасан.



Дундговь аймгийн Засаг даргын 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн а/316 дугаар захирамжаар "Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалын зүйл гардуулах, хөрөнгө зарцуулах журам"-ыг баталсан Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 3-т заасан "Эрхэлсэн асуудлын хүрээний байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагын удирдлагаас ёслолын арга хэмжээнд зарцуулах зардлын нормативыг Сангийн яамтай зөвшилцөн тогтоож мөрдүүлж ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай." гэснийг зөрчсөн.

Мөн хууль тогтоомжоор тусгайлан эрх олгоогүй байхад аймгийн Засаг даргын 2018 оны 3 сарын 23-ны өдрийн а/118 дугаар захирамжаар "Техник хяналтын зардлыг захиран зарцуулах журам" баталсан байна. Журамд техник хяналт тавихад шаардлагатай автомашин, ... тавилга эд хогшил худалдан авах, дараа жил хийгдэх ажлын зураг төсөв хийх зардлыг санхүүжүүлэхээр тусгаж, энэ хүрээнд Засаг даргын захирамжийн дагуу 17 945 000 төгрөгөөр "Ерөө эрдэс" ХХК-иас автомашин худалдан авсан, Говь-Угтаал сумын спорт заалны зураг төсвийн үнэд 17 710 000 төгрөгийг "Гэгээн дизайн" ХХК-д шилжүүлсэн (магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй, ажил хүлээж аваагүй байхад санхүүжилтийг хийсэн, Засаг дарга 14 800 000 төгрөгийг шилжүүлэх захирамж гаргасан байтал БХБГХГ-аас захирамжид дурдсан хөрөнгийг нэмэгдүүлж шилжүүлсэн) зэрэг зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй.

#### #4. ЗӨВЛӨМЖ

**Дундговь аймгийн Засаг даргын 2014 оны а/316 дугаар захирамжаар баталсан "Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалын зүйл гардуулах, хөрөнгө зарцуулах", 2018 оны а/118 дугаар захирамжаар баталсан "Техник хяналтын зардлыг захиран зарцуулах журам"-ыг тус тус хүчингүй болгох**

**#5. ЗӨВЛӨМЖ**

**Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг чангатгах, хугацаа хэтэрсэн зээлийг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх, тус сангийн дансанд бусад эх үүсвэр бүхий хөрөнгийг байршуулахгүй байх, албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон өөрийн хамаарал бүхий этгээдэд зээл олгосон гэмт хэргийг давтан гаргуулахгүй байх**

Сум хөгжүүлэх сангаас өмнөх жилүүдэд зээл авсан боловч зээлийн эргэн төлөлт хийгээгүй Баянжаргалан сумын 6 иргэн (Г.Энхтайван – авто засвар 15 сая, Э.Маралмаа – сүү, сүүн бүтээгдэхүүн 5 сая, Л.Цэрэнбаяр – компьютер хэвлэлийн үйлчилгээ 7 сая, Ц.Ягаанцэцэг – хэрчсэн гурил нарийн боов 10 сая, Ж.Норжин – оёдол 2 сая, Г.Оюунбат – гахайн аж ахуй 10 сая)-ний авсан 49 000 000 төгрөг, Гурвансайхан сумын 9 иргэн (Э.Отгонбаатар – компьютерийн үйлчилгээ 5 сая, Х.Өлзийрагчаа – мах сүү, сүүн бүтээгдэхүүн 5 сая, Х.Булганбаатар – зайрмагны цех 20 сая, Д.Жаргалсайхан – автозасвар 4 сая, М.Батсүх – хүнсний ногоо тариалах 3 сая, Ч.Эрдэнэцэцэг – цайны газар 4,3 сая, Ц.Батболд – гутал засвар, оёдол 8 сая, Ш.Гантулга – блок 4 сая)-ний 53 300 000 төгрөгийг тус тус шүүхээр хянан шийдвэрлүүлэх шаардлагатай.

Баянжаргалан суманд үйл ажиллагаа явуулж байсан ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий "Эм Си Ти Ти" ХХК-иас ажиллах хүчний зөрүү гэж 2009 онд 22 500 000 төгрөг хүлээн авсныг Сум хөгжүүлэх сангийн дансанд байршуулан уг эх үүсвэрээс төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хүүтэй зээл олгож, зээл болон зээлийн хүүг төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.4-д заасан буюу **тус сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө уг дансанд байршуулахыг хориглосон зохицуулалтыг зөрчсөн.**

Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхтуяа, Санхүүгийн албаны дарга Ү.Алимаа нар нь сонгон шалгаруулалт зарлаагүй байхад албан тушаалын давуу байдлаа ашиглан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс өөрийн хамаарал бүхий этгээдэд нийт 33 000 000 төгрөгийн зээлийг гаргуулсан асуудлаар Авлигатай тэмцэх газраас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.



Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан "Түүхт Баянжаргалан" ТББ-ын ХААН банкин дахь 5450604184 тоот дансанд хандив төвлөрүүлсэн байх ба хандивын хөрөнгийг сумын Засаг дарга Г.Туяа захиран зарцуулдаг. Тодруулбал, "Говьшоо" ХХК, "Тайшэндевелопмент" ХХК, "Дүншли" ХХК, "Тайхар орд" ХХК, "Дэжиэ" ХХК, "Биг могул" ХХК, "Циркон геологи" ХХК, "Эм Жи Би" ХХК, "Аргатай" ХХК, "Окслей Айрон" ХХК-аас нийт 60 800 000 төгрөгийг 2017.05.09-ний өдрөөс 2018.10.30-ны өдрийг хүртэлх хугацаанд дээрх дансанд төвлөрүүлж, малчны баяр, шинэ жил, аялал, бараа материал худалдан авах, эмнэлэг, ЗДТГ-ын автомашины засвар, урлагийн наадам, сүлдний үнэ зэрэгт 56 811 700 төгрөгийг зарцуулжээ.

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана." гэсэн байх ба Баянжаргалан сумаас гэрээний үндсэн дээр төвлөрүүлж байгаа хөрөнгө нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэхэд зарцуулагдаагүй байна.

## #6. ЗӨВЛӨМЖ

**Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй Засаг даргаас хамтран ажиллах гэрээ байгуулан хандив цуглуулдаг, хандивын хөрөнгийг зориулалтын бусаар дур мэдэн хяналтгүйгээр зарцуулдаг явдлыг таслан зогсоох.**



## #7. ЗӨВЛӨМЖ

**Орон нутгийн төсөвт техник, эдийн засаг үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусган батлах, хууль тогтоомжийг зөрчиж худалдан авах ажиллагааг төлөвлөн зохион байгуулахгүй байх**

Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар 04-ны өдрийн “Орон нутгийн 2018 оны төсөв батлах тухай” 25 дугаар тогтоолоор баталсан “Дундговь аймгийн 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 1.2.5-д заасан 150 сая төгрөгийн өртөгтэй аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх арга хэмжээ, “Дундговь аймгийн 2018 оны орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 1.1-д заасан 500 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын үргэлжлэл” төсөл, арга хэмжээний **техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв** тус тус батлагдаагүй байв.

Өөрөөр хэлбэл, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэснийг зөрчин Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь санал оруулж, Орон нутгийн 2018 оны төсөвт тусган батлуулжээ.





Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.9-д зааснаар захиалагч нь “гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах” эрхтэй. Тус аймгийн хэмжээнд 2018 онд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр нийт 40 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэхээс 37 төсөл арга хэмжээг (2018.11.02-ны байдлаар) хэрэгжүүлсэн. Гэтэл эдгээр төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч нар хуульд заасан дээрх мэдээлэл бүхий самбарыг олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулаагүй байв.

## #8. ЗӨВЛӨМЖ

**Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн явцад иргэн, иргэний нийгмийн байгууллага, сонирхогч этгээдээс хяналт тавих боломжийг олгох, ил тод нээлттэй байдлыг хангах.**

## #9. ЗӨВЛӨМЖ

**Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд тавих хяналтыг чангатгах, гарсан зөрчлийг тухай бүр арилгуулах**

Тус аймгаас зохион байгуулсан тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой 2017 онд 8, 2018 онд 7 (3 дугаар улирлын байдлаар), нийт 15 гомдлыг Сангийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас шалган үзээд 10 (2017 онд 6, 2018 онд 4)-ыг нь “захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол нь үндэслэлтэй” гэж үзсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 46 дугаар зүйлийн 46.1.2-д заасан захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахад анхаарах шаардлагатайг харуулж байна.



## #10. ЗӨВЛӨМЖ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-д заасан “энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.” гэснийг мөрдөхгүй байна. Тодруулбал, нээлттэй тендер шалгаруулалт 2 удаа амжилтгүй болж, гэрээ шууд байгуулах нөхцөл үүссэн үед үнэлгээний хороо нь хуулийн 14 дүгээр зүйлд заасан “ерөнхий нөхцөлийг магадлах”, 15 дугаар зүйлд заасан “санхүүгийн чадавхийг үнэлэх”, 16 дугаар зүйлд заасан “техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх” замаар гэрээ хийх байтал тендер шалгаруулалтад оролцоод шаардлага хангаагүй гэж үзсэн оролцогчийг шалгаруулдаг, эсхүл хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлагыг магадлан үнэлэхгүйгээр “гэрээ шууд” байгуулдаг байна. Тухайлбал, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэдалай суманд хог зөөврийн машин 45 сая төгрөгөөр худалдан авах тендер “Дашноров” ХХК, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Эрдмийн далай” цогцолборын сургуулийн сантехникийн засварын 68 сая төгрөгийн тендер “Ган-илч” ХХК-ийг тус тус шалгаруулсан.

**Үнэлгээний хороо нь Нээлттэй тендер шалгаруулалт 2 удаа амжилтгүй болж, гэрээ шууд байгуулах нөхцөл үүссэн үед уг аргыг хуульд заасны дагуу хэрэгжүүлж гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид хүргүүлэхдээ хуульд заасан шаардлагыг “хамгийн сайн хангасан этгээд”-тэй гэрээ байгуулах зөвлөмжийг өгдөг байх.**

**#11. ЗӨВЛӨМЖ**

***Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр хуульд заасны дагуу тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах, хавтаст хэрэгт үнэлгээний хорооны гишүүний худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээ (А-3)-г хавсаргах***

Тус аймагт зохион байгуулсан худалдан авах ажиллагааны баримт бичигтэй танилцах явцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-д заасан зарим баримт, материалууд хавтаст хэрэгт байхгүй байсан нь хяналт шалгалтын ажлыг явуулахад хүндрэлтэй байлаа. Тухайлбал, хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.1-ээс 49.2.7-д заасан баримт материал нь Орон нутгийн өмчийн харилцааны газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтанд, хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.8-аас 49.2.10-т заасан баримт материал нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэнд тус тус

Дундговь аймгийн Засаг дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн нөхцөл тогтоогдоогүй байхад тендер зарлалгүй “Таванбогд” ХХК-тай “гэрээ шууд” байгуулж Ланд круйзер-200 марк (195 000 000 төгрөг)-ийн авто машиныг, “Билэгт-Удам” ХХК-тай “гэрээ шууд” байгуулж Эксковатор (130 000 000 төгрөг) худалдан авсан нь бусдад давуу байдал үүсгэсэн нөхцөл тогтоогдож, хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байна

**#12. ЗӨВЛӨМЖ**

***Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал тохиолдсон шалтгаанаар Худалдан авах ажиллагааны аргыг сонгохоос зайлсхийж, бусдад давуу байдал үүсгэсэн гэмт хэргийг давтан гаргахгүй байх.***

**#13. ЗӨВЛӨМЖ**

**Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, журмын 4.1-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.**

Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн (журмыг <https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778>-ээс татаж үзэх).

Журмын 4.1-т “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасан.

